

Хөтөлбөр

Суурь хичээлүүд	Элсэлт авах хичээл	Судлах хичээлүүд
S-/G курс	Гадаад хэл, хүмүүнлэгийн ухаан, урлаг болон нийгмийн ухааны чиглэлийн сургалт	<ul style="list-style-type: none">Герман хэлНийгэм судлалТүүхХүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь
T-курс	Математик технологи болон байгалийн шинжлэх ухаан	<ul style="list-style-type: none">Герман хэлМатематикФизикХимиМэдээлэл зүй
W-курс	Нийгэм болон эдийн засгийн ухаан	<ul style="list-style-type: none">Герман хэлЭдийн засагМатематикНийгэм судлал

ISSK-гийн суурь хичээлүүдийн курсуудад авах онлайн шалгалт

Суурь хичээлүүд	Элсэлт авах хичээл	Элсэлтийн шалгалтыг онлайнгаар өгнө. 30 минутын хугацаатай үргэлжлэх онлайн элсэлтийн шалгалтад мэргэжлийн хичээлийн суурь мэдлэгийг шалгана.
S-/G курс	<ul style="list-style-type: none">Хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь	
T-курс	<ul style="list-style-type: none">Математик	
W-курс	<ul style="list-style-type: none">Математик	Шалгалтад тэнцсэнээр ISSK-д элсэн суралцах боломжтой.

ISSK элсэлтийн шалгалтад бэлтгэж байгаа суралцагчдад зориулан дараах онлайн сургалтуудыг санал болгож байна.

>> www.issk.uni-mainz.de/studienkolleg/online-kurse/

ISSK оюутнууддаа чиглэсэн зөвлөх үйлчилгээг сургууль дээрээ зохион байгуулж байна.

>> www.issk.uni-mainz.de/studienkolleg/kontakt/

DOWNLOAD-CENTER

Weitere Informationen: Broschüren, Videos, Podcast, ...



<https://www.issk.uni-mainz.de/issk-downloads/>

Холбоо тогтоох

ISSK – Internationales Studien- und Sprachenkolleg

Johannes Gutenberg-Universität Mainz

Binger Str. 14-16 | 55122 Mainz



<https://www.issk.uni-mainz.de/>

Johannes Gutenberg-Universität Mainz
55099 Mainz



<https://www.uni-mainz.de/>

Photos © Piyaset – shutterstock.com (Cover) | Alexander Sell



ОЛОН УЛСЫН ХЭЛНИЙ
БЭЛТГЭЛ КОЛЛЕЖ
(ISSK)-ИЙН ДЭРГЭДЭХ
ГЕРМАН ХЭЛНИЙ
БЭЛТГЭЛ КУРС


B2 түвшинд бэлтгэх хосолсон сургалт Их сургуулийн өмнөх бэлтгэл коллежид суралцах гүүр болох нь

Internationales
Studien- und
Sprachenkolleg



Олон улсын хэлний бэлтгэл коллежийн түвшин тогтоох шалгалт(FSK)-д бэлтгэх сургалтуудад хамрагдахын тулд Герман хэлний B2 түвшний мэдлэгтэй байх шаардлагатай.

Герман хэлний эрчимжүүлсэн хөтөлбөртэй бэлтгэл курсын зорилго нь суралцагчдыг B2 түвшний хэлний мэдлэгтэй болгох зорилготой. Суралцагчид гэрээсээ ISSK хөтөлбөрийн бүх үйл ажиллагаанд оролцох давуу талтай. ISSK нь хосолсон сургалт буюу үндсэн ангийн хичээл, группээр ажиллах сургалтыг зохион байгуулдаг.



Долоо хоногт 15 цаг үргэлжлэх сургалт нь онлайн хичээл, бие даалтын цагуудаас бүрдэнэ. Сургалтын материалын баялаг бааз дээр түшиглэн суралцагч өөрөө бие даан цаг хугацааны хувьд уян хатан байдлаар үр өгөөжтэй суралцах боломжтой. Бие даан суралцах хэсэгт хичээлээ давтах, шинэ үг сурах цаг ордог. Хичээлийг герман хэл заах арга зүйн туршлагатай багш нар удирдан явуулдаг. Гэрээсээ онлайнар хичээлд хамрагдаж байгаа оюутнууд Майнц хотод байгаа суралцагчидтай цуг суралцах боломжтой.

Ингэснээр оюутнууд Германд очихоосоо өмнө харилцаа холбоо тогтоож, харилцааны ур чадвараа дээшлүүлж, шалгалтандаа өргөн цар хүрээнд бэлдэх боломжтой.



Сургалтын давуу тал:

Тус курс нь уламжлалт танхимын сургалт болон технологид суурилсан онлайн сургалтыг хослуулсан. Гадаад орноос суралцаж буй суралцагчид хичээлдээ онлайнар оролцох, бусад суралцагчидтай харилцах, үзсэн хичээлээ бататгах, сурсан зүйлээ практикт хэрэглэдэг учир орон зай үл хамааран сурлагын амжилт гаргах боломжтой. Мөн бие даан суралцахад зориулсан хангалттай сургалтын материал бий тул суралцагч өөрийн сурах хурдтайгаа тааруулах боломжтой. Тухайн суралцагч багш нар, бусад суралцагчидтай байнга холбоотой байснаар өөрийгөө илэрхийлэх чадвар мэдэгдэхүйц сайжирна.



Түүнчлэн Майнц хотод герман хэл суралцаж байгаа суралцагчид болон гадаад орноос суралцаж байгаа суралцагчдын харилцаа холбоог дэмжиж өгч байгаагаараа давуу талтай.

Түнш сургуулиудын төгсөгчдийн өргөдөл, элсэлтийн журам

Зөвхөн намрын семестерт эхэлнэ

4-р сар

Монгол улсад элсэлтийн цахим шалгалт өгөх

Хугацаа 5-р сарын 15

Элсэлтийн шалгалтад тэнцсэний дараа JGU-д элсэх хүсэлтээ онлайнар гаргах

8-р сар

Бэлтгэл коллежид элсэн орох болзолыг хангах

8-р сар

Бүрэн дунд боловсролын гэрчилгээг баталгаажуулах

8-р сар – 1-р сар

ГЕРМАН ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ КУРС
Онлайн: B1 > B2

Майнц руу нүүх

JOHANNES GUTENBERG
UNIVERSITÄT
MAGN. JGU

2-р сар – 7-р сар

ГЕРМАН ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ КУРС амжилттай дүүргэсний дараа ISSK-ийн үндсэн сургалтад хамрагдах

7-р сар

ТТШ-д тэнцсэний дараа мэргэжлийн сургалтад хамрагдах

DSD I диплом олгодог түнш сургуулийн төгсөгчдөд зориулсан ГЕРМАН ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ КУРС

DSD I диплом олгодог түнш сургуулийн төгсөгчдөд зориулсан ГЕРМАН ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ КУРСТ эх орноосоо онлайнар сурангаа B2 түвшний хэлний мэдлэгтэй болох боломжтой. Уг курст амжилттай суралцсанаар Майнц хотын Их сургуулийн өмнөх бэлтгэл коллежийн үндсэн хичээлд үргэлжлүүлэн суралцах үүд хаалга нээгдэнэ. Ингэснээр Герман улсын хэл, соёл, боловсролын орчинтой урьдчилан танилцах боломж бий болох юм.